



РАДИО УДИРДЛАГАТ УРАН НИСЛЭГИЙН ЗАГВАР

МАСТЕР АНГИЛАЛ 2020-2021

ШҮҮГЧ, ТАМИРЧДЫН ГАРЫН АВЛАГА



Шүүгчид өгөх зөвлөгөө

1. Шүүгчид өгөх ерөнхий зөвлөгөө

- **Тэмцээний талбайд эрт ир.** Тэмцээнд нисэх дасгалуудтай урьдчилан танилцаж, нислэгийн талбайн шугамуудын байрлалыг харж ав. Нислэг үйлдэх үед тамирчны байрлах цэгт зогсож, нислэгийн орон зай хаана дуусч байгааг тухайн газар орны байдалтай уялдуулан тодорхойл. Дараа нь шүүгчийн байрнаас мөн нислэгийн орон зай хаана дуусч байгааг тогтоож авсан байх хэрэгтэй.
- **Бэлтгэлтэй бай.** Тохилог сандал, нарны шил, малгай, нарны саравч, хүрэлцэхүйц уух ундаа авч ирэх нь зүйтэй. Цаг уурын нөхцөлд тохируулан хувцасласан байх хэрэгтэй.
- **Тохилог, тухтай суу.** Суудал дээрээ байрлалаа тогтмол өөрчилж бай. Нислэгийн завсарлагааны үед босч биеийн чилээ гаргаж байх нь зүйтэй.
- **Байрлалаа зөв сонго.** Шүүгчид нислэг үйлддэг буй тамирчдын ард, 5-10 метрийн зайнд сууна. Хэт ойр суувал нислэг үйлдэж буй тамирчин болон түүний туслах шүүгчийн харах орчинг хязгаарлана. Мөн сүүдрэвч шүүгчийн харах орчинг хязгаарлахгүй байхаар шүүгчид байрлах хэрэгтэй.
- **Өөрийн бичигчийг сурга.** Нислэгийн талаар болон өөрийн өгч буй оноог бичигчид хэрхэн хэлэх талаар бичигчид тайлбарлаж өгөх нь зүйтэй. Бичигч нь зөвхөн оноог зөв тэмдэглэх үүрэгтэй бөгөөд нислэгийг харах шаардлагагүй гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Бичигчийн ажиллах орчныг бүрдүүлэхэд анхаар.
- **Эелдэг, найрсаг бай.** Гэхдээ шүүх үед харилцан яриаг хязгаарла. Тамирчны анхаарлыг сарниулахаас болгоомжил.

2. Оноо өгөх

- **Өөртөө итгэлтэй бай.** Шүүгч Та тэмцээнийг шүүх зарчим, үндэс, оноо өгөх журмыг мэдэх учраас өөрийн боломжийг бүрэн дайчилж шүүх ажиллагааг гүйцэтгэх хэрэгтэй. Хэрэв Та аль нэг дасгалыг харж амжаагүй бол нислэгийн хуудсанд Хараагүй-“ХГ” гэж тэмдэглэнэ. Дасгалд таамгаар, эсвэл өмнөх дасгалтай адилтган оноо өгч болохгүй.
- **Биеэ даасан байдал.** Бусад шүүгчдийн өгч буй оноог бүү анхаар. Өгөх онооны талаар бусад шүүгчидтэй зөвлөлдөж, хэлэлцэж болохгүй, зөвхөн өөрийнхөө итгэл үнэмшлээр оноо өгөх хэрэгтэй. Дасгалд оноо өгмөгц түүний тухай бодлоо орхиж дараагийн дасгалд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Зөвхөн хасах онооны нийлбэрээр оноо өг. Аливаа дасгалд орох

шулуун нислэгээс эхлэн дасгалаас гарах шулуун нислэг хүртэл анхаарлаа төвлөрүүл. Хасах оноонуудаа өгч, хооронд нь нэм. Дасгалыг ерөнхийд нь харж, төрсөн сэтгэгдлээрээ оноо өгч болохгүй.

- **Өгсөн оноогоо бич.** Өгсөн оноогоо тусгай тэмдэглэх хуудсан дээр, нислэгээс хараагаа салгахгүйгээр тэмдэглэ. Ингэснээр анх өгсөн оноог хадгалж, бичигч алдаа гаргасан нөхцөлд бичлэгийг ашиглах боломж бүрдэнэ. Тэмдэглэх хуудсанд бичсэн оноог бичигч албан ёсны нислэгийн хуудсанд бичиж буулгана. Бичигч байхгүй тохиолдолд нислэгийн хоорондох завсарлагыг ашиглан шүүгч өөрөө оноог нислэгийн хуудсанд бичиж буулгана.
- **Тамирчны болон бусад шүүгчийн анхаарлыг бүү сарниул.** Өгч буй оноогоо бичигчид амаар хэлэх нь бусад шүүгчдэд сонсогдож болохыг, мөн бичигч алдаа гаргаж болохыг анхаар. Дээр дурдсан тэмдэглэх хуудсыг ашигла. Хасах оноог нэмэхэд гар хуруугаа ашиглах нь бусад шүүгчдэд саад болж магадгүй тул санаандаа 10-аас эхлэн хасах аргыг хэрэглэ.

3. Шүүх зарчим

Радио удирдлагат уран нислэгийн тэмцээнийг шүүхдээ тамирчин нислэгийн дасгалуудыг төгс төгөлдөр гүйцэтгэж байгааг шүүн тунгаах зарчмыг баримтална. Тамирчны гүйцэтгэж буй дасгал хэр зэрэг төгс төгөлдөр болж байгааг дараах 4 шалгуурыг ашиглан хэмжинэ. Үүнд:

1. дасгалын нарийн зөв, нягт нямбай байдал
2. дасгалын тасралтгүй, уран сайхан байдал
3. дасгалын байрлал, үзэгдэх байдал
4. дасгалын хэмжээ

Дээрх шалгууруудыг ач холбогдлоор нь дараалуулан жагсаасан бөгөөд аливаа дасгалыг үнэлж дүгнэхэд эдгээр шалгууруудыг бүгдийг нь авч үзэх шаардлагатай.

- **Нарийн зөв, нягт нямбай байдал.** Загвар аливаа дасгалын геометр дүрсийг хэр зэрэг зөв зурж буйг үндэслэн дасгалын нарийн зөв, нягт нямбай байдлыг үнэлнэ. Нислэгийн дасгалуудыг салхины нөлөөллийг засварлан гүйцэтгэнэ. Загварын хүндийн төв дасгалын геометр дүрсийг хэрхэн зурж байгааг үнэлэх ба загварын нислэгийн давших өнцгийг үнэлгээнд харгалзан үзэхгүй.
- **Тасралтгүй, уран сайхан байдал.** Дасгалыг тасралтгүй, жигд, уран гоё гүйцэтгэж буй эсэхийг үнэлнэ. Тухайлбал бүрэн төгс торхны эргэлтийн хурд эхнээсээ дуустлаа жигд тогтмол байх ёстой. Мөн цагариг тогтмол радиус бүхий зөв тойрог үүсгэсэн байх бөгөөд хэд хэдэн цочмог татсан

- өнцөг бүхий шулуун нислэгүүдээс бүрдсэн байж болохгүй гэсэн үг юм.
- **Байрлал.** Хөөрөлт, суултаас бусад бүх дасгалууд нислэгийн хайрцаг (орон зай)-т үйлдэгдсэн байх ёстой. Төвийн дасгалууд нислэгийн орон зайн төв шугамд перпендикуляр хавтгайд хийгдэнэ. Захын дасгалууд нислэгийн орон зайн гадна гарч болохгүй. Захын дасгалууд нь нислэгийн байрлалыг тогтоох дасгалууд учраас тэдгээрт орох ба гарах өндөр харилцан өөр байж болно.
- **Хэмжээ.** Гол шалгуур нь загвар шүүгчдэд сайн харагдаж байх явдал юм. Том хэмжээтэй, сайн харагддаг загвар тамирчнаас 175 орчим метрт нисэхэд хангалттай байхад бага хэмжэтэй, муу харагддаг загвар 140-150 метрт нисэх хэрэгтэй болдог. 175 метрээс цааш зайнд хийсэн дасгалд оноо хасна. Шүүгчээс нислэгийн шугам хүртэлх зайнаас хамааран нислэгийн орон зайн хэмжээ өөрчлөгддөг учир дасгалын хэмжээ мөн адил үүнээс хамааран өөрчлөгдөнө. Дасгалыг үнэлэхэд дасгалын хэмжээ чухал биш. Тамирчин нислэгийн орон зайн хэмжээ, бусад дасгалын хэмжээ зэрэгтэй уялдуулан тухайн дасгалын хэмжээг тодорхойлно. Ойр зайнд, бага хурдтайгаар, жижиг хэмжээтэй дасгал хийх, хол зайнд илүү хурдтай загвараар том хэмжээтэй дасгал гүйцэтгэх хоёр адил үнэлгээтэй байна. Шүүгч загварын нисэх үзүүлэлтийг үнэлэхгүй, харин тамирчин дасгалаа хэрхэн гүйцэтгэж байгааг үнэлэх ёстой.

4. Оноо бууруулах нөхцлүүд

Шулуун нислэг: хасах оноо

Нислэгийн тогтоосон шугамаас 15 градус хазайх тутам	1 оноо (1/150)
Хоёр дасгалын дунд шулуун нислэг хийгээгүй бол дараачийн дасгалаас	2
Шулуун нислэгийн урт бага зэрэг алдагдсан	1
Шулуун нислэгийн урт нэлээд алдагдсан	2, түүнээс дээш
Торхны дараа шулуун нислэг хийгээгүй, тухай бүрд	2
Торхны өмнөх болон дараах шулуун нислэгийн урт тэнцүү биш	1

Цагариг:

Радиус бага зэргийн өөрчлөлттэй	1
Радиус нэлээд өөрчлөлттэй	2-3
Цагаригийн зарим хэсэг мэдэгдэхүйц шулуун	1
Цагариг хажуу тийш бага зэрэг туугдан шилжсэн	1
Цагариг хажуу тийш нэлээд туугдан шилжсэн	2-3

Хагас цагаригуудын радиус харилцан адилгүй, тухай бүрт, (бага зэрэг)	1
Хагас цагаригуудын радиус харилцан адилгүй, тухай бүрт, (нэлээд)	2, түүнээс дээш

Торх:

Торхны эргэлтийн хурд тогтмол бус, тухай бүрт, (бага зэрэг)	1
Торхны эргэлтийн хурд тогтмол бус, тухай бүрт, (нэлээд)	2, түүнээс дээш
Торхны алдаа бүхий эхлэл ба төгсгөл, тухай бүрт	1
Торхны эргэлтийн өнцөгт гарсан алдаа бүрт	1/150
Байрлалт торхны завсарлага харилцан адилгүй, тухай бүрт, (бага зэрэг)	1
Байрлалт торхны завсарлага харилцан адилгүй, тухай бүрт, (нэлээд)	2, түүнээс дээш
Байрлалт торх илүү, эсвэл дутуу байрлалтай	5, түүнээс дээш

Цагариг/торхны хослол:

Иммельман эргэлтийн үед цагариг, торхны хооронд шулуун нислэг орсон	2
Иммельман эргэлтийн үед цагариг дуусахаас өмнө торх эхэлсэн	1/150
Лавина дасгалд штопортой торх хийх үед цагаригийн радиус өөрчлөгдсөн	1, түүнээс дээш
“Гутал” дасгалын оройн болон доод талын цагаригуудын радиус харилцан адилгүй	2, түүнээс дээш
“Малгай” дасгалын оройн нислэг нуруугаар хараагүй	“0” (тэг оноо)
Захын “Малгай” дасгалд оройн болон доод талын шулуун нислэг хийгээгүй	5
Захын “Малгай” дасгалд оройн болон доод талын шулуун нислэгийн шугамын урт босоо шугамаас богино	оноо хасахгүй
Захын “Малгай” болон “Гутал” дасгалын босоо нислэгийн шугамуудын урт харилцан адилгүй	оноо хасахгүй

Зогсолттой эргэлт:

Эргэлтийн радиус далавчны далайцын ½ -ээс их	1
Эргэлтийн радиус далавчны далайцын 1½ -ээс их	2, түүнээс дээш
Зогсолттой эргэх үед савлах хөдөлгөөн үүссэн	1
Зогсох үед торх эргэх хөдөлгөөн үүссэн	1/150

Салхины үйлчлэлийг засварлах зорилгоор загварын эргэлтийн өнцөг 180 градусаас бага	оноо хасахгүй
--	---------------

Штопортой торх:

Завсарлагагүй, гэхдээ эргэлтийн явцад зогсолт эхэлсэн	5, түүнээс дээш
Зогсолтгүй, ердийн торх эргэсэн	“0” (тэг оноо)
Эргэлтийн өнцөг алдагдсан	1/150
Нислэгийн чиглэл алдагдсан	1/150

Штопортой торх хийх үед загварын хурд өөрчлөгдөхийг зөвшөөрнө.

Штопор:

Далавч тэгш бус	1/150
Штопорын төгсгөлд далавч нислэгийн шугамд перпендикуляр биш	1/150
Загвар тууш тэнхлэгээ тойрон ½-ээс илүү эргэлдэж шумбасан	“0” (тэг оноо)
Штопорын үед загварын их бие конус зураагүй	“0” (тэг оноо)
Загварын хошуу хэвтээ хавтгайг огтлохоос өмнө загварын далавч босоо хавтгайг огтолсон	“0” (тэг оноо)
Штопор эхлэхээс өмнө загварын их бие босоо байрлалд орсон	“0” (тэг оноо)
Штопорын үед загвар салхинд туугдахад	оноо хасахгүй
Штопорт ороход зогсолт хийх ёстой, гэхдээ газартай харьцуулсан хурд тэг байх шаардлагагүй.	

Байрлал:

Голын дасгал төвийн шугамд голлоогүй	2
Захын дасгал нислэгийн хайрцгийн гадаа хэсэгчлэн гарсан	2
Захын дасгал нислэгийн хайрцгийн гадаа бүхэлдээ (дасгалд орох ба дасгалаас гарах шулуун нислэгийн хамт) гарсан	“0” (тэг оноо)
Дасгалыг шүүгчдээс 175-200 м-т хийсэн бол	1
Дасгалыг шүүгчдээс 200-250 м-т хийсэн бол	2
Дасгалыг шүүгчдээс 250 м-ээс цааш хийсэн бол	3

Суулт:

Суултын өмнөх хайрцаг хийхэд загварын байрлалд	оноо хасахгүй.
--	----------------

Загвар гүйлтийн талбай буюу төвийн шугамаас хааш хаашаа 50 метрт газардах ёстой.

Дээд оноо авахын тулд загвар суултын талбайд буюу төвийн шугамаас хааш хаашаа 30 метрт газардах ёстой.

Загвар суух үед давших өнцөг их байхыг шаардахгүй.

Загвар газардсаны дараа 10 метр гүйснээр оноо өгөхийг зогсооно.

Бусад:

Маш бага алдаанд ½ оноо хасч бодно. Тухайлбал 7,5 градуст ½ оноо гэх мэт.

Бүх дасгалыг салхины үйлчлэлийг засварлан хийх ба

алдаа гарвал 1/150 дүрмийг баримтлан оноо хасна.

- Дасгалын геометр дүрсийг харгалзан оноо өгөх ба загварын давшилтын өнцгийг харгалзахгүй.
- Загварын нисэх шинж чанар, үзүүлэлт оноонд нөлөөлөхгүй.
- Захын дасгалуудад орох ба тэдгээрээс гарах өндөр өөр байж болно.


М-1. Хөөрөлт (Салхины өөд)

Санамж

1. Хөдөлгүүр асаалттай загварыг гарааны шугамд заавал хөдөлгөөнгүй зогсоохыг шаардахгүй.
2. Гараанаас төв шугам хүртэл гүйлтийн зайтай ижил зайнд загварыг 2 метрийн өндөр авахуулсан байхыг шаардахгүй.
3. Загвар хөөрөх үед агаарын хуйлралаас шалтгаалан далавч хазайхад (хазайлтыг тэр дор нь зассан бол) оноо бууруулахгүй.
4. Загвар ойролцоогоор 2 метрийн өндөрт гарсан бол дасгал дууссанд тооцно.

Оноо бууруулах

1. Загвар гүйх үедээ харайлгасан,
2. Талбайн төв шугамаас хоёр тийш нэг метрийн дотор газраас тасраагүй,
3. Загвар агаарт гарсны дараа дахин газарт хүрсэн,
4. Хөөрөх өнцөг хэт их,
5. Загвар хөөрч байх үедээ “цогисон”,
6. Далавч хазайлттай,
7. Гүйлтийн үед алгуур хурд аваагүй,
8. Гүйлтийн болон хөөрөлтийн дасгал дуусах хүртэлх үед (газраас 2 орчим метрийн өндөрт гарах хүртэл) нислэгийн чиглэл алдагдсан,
9. Загвар нислэгийн аюулгүйн шугамыг давсан бол “0” оноо




Хөөрөлтийн дараах оноогүй шулуун нислэг (Салхины уруу)

Санамж:

Дасгалын хайрцагт орохдоо 15-аас доошгүй метр шулуун нислэг хийсний дараа ээлжит дасгалыг эхэлнэ.

Оноо бууруулах:


Дасгалын хайрцагт орох 15-аас доошгүй метр шулуун нислэгийг хийгээгүй бол дараагийн дасгалаас нэг оноо хасна.



М-2. 45° өгсөх нислэг, 4 байрлалт торхтой (Салхины өөд)

Оноо бууруулах:



1. Цагаригуудын сегментүүд зөв тойрог үүсгээгүй, тэдгээрийн радиус харилцан адилгүй,
2. Өгсөх нислэгийн шугам 45° биш,
3. Байрлалт торхны байрлалууд 90°, 180°, 270°, 360° биш, 15°-ын алдаа тутам 1 оноо хасна,
4. 180° байрлалыг өгсөх шугамын эгц голд хийгээгүй,
5. Торхнуудын эргэлтийн хурд жигд бус,
6. Дасгалын үед нислэгийн чиглэл алдагдсан.



М-3. Дээрээс эхлэх хагас дөрвөлжин цагариг, доош хагас торхтой (Захын)

Оноо бууруулах:

1. Цагаригуудын сегментүүд тэгш тойрог үүсгээгүй, сегментүүдийн радиус харилцан адилгүй,
2. Дасгалыг хийх үед загварын нислэгийн чиглэл алдагдсан,
3. Торхыг уруудах шугамын голд хийгээгүй,
4. Торхны эргэлт илүү, эсвэл дутуу,
5. Уруудах нислэгийн шугам эгц босоо биш.




М-4. Удаан торх (Салхины уруу)

Санамж:

1. Торхны эргэлт зүүн, эсвэл баруун байж болно,
2. Загвар 180° эргэж, урвуу харсан цэг нь талбайн төв шугамыг голлосон байна.

Оноо бууруулах:


1. Нислэгийн чиглэл алдагдсан,
2. Нислэгийн өндөр өөрчлөгдсөн,
3. Торхны эргэлт 360° -аас их, эсвэл бага,
4. Торхны үргэлжлэх хугацаа 3 секундээс бага,
5. Торхны эргэлтийн хурд тогтмол бус.



М-5. Хагас куба найм, 45° уруудах шугамд бүтэн торхтой /урвуу гаралттай (Захын)

Оноо бууруулах:


1. Цагаригийн сигмент зөв тойрог үүсгээгүй,
2. Уруудах нислэгийн шугам 45° биш,
3. Цагариг болон торх хийх үед нислэгийн чиглэл алдагдсан,
4. Торхыг 45° -ын уруудах шугамын голд хийгээгүй,
5. Торхны эргэлт илүү эсвэл дутуу.



М-6. Дээрээ суурьтай гурвалжин цагариг, эерэг штопор торхтой (Салхины өөд)

Оноо бууруулах:

1. Цагаригуудын сегментүүд зөв тойрог үүсгээгүй, тэдгээрийн радиус харилцан адилгүй,
2. Дасгалыг хийх үед загварын нислэгийн чиглэл алдагдсан,
3. Торхны эргэлтийн хурд жигд бус,
4. Торхны эргэлт илүү, эсвэл дутуу,
5. Өгсөх ба уруудах нислэгийн шугамууд 45° биш,
6. Өгсөх ба уруудах шугамуудын урт тэнцүү биш,
7. Торх хэвтээ шугамын голд хийгдээгүй.





М-7. “Малгай”, дээш 3/4 торх, доош 1/4 торхтой /урвуу оролттой (Захын)

Санамж:

Малгайн оройд урвуу харсан шулуун нислэг хийгдэх ёстой.

Оноо бууруулах:


1. Торхнуудын өмнө болон дараа загварын дагуух тэнхлэгийн шугам эгц босоо бус,
2. Торхнуудын эргэлт 90° ба 270° бус,
3. Дасгалын оройн урвуу харсан нислэгийн шугам шулуун бус, нислэгийн босоо шугамуудтай 90° үүсгээгүй,
4. Торхнуудыг тухайн шугамуудын голд хийгээгүй,
5. Цагаригуудын сегментүүд зөв тойрог үүсгээгүй, тэдгээрийн радиус харилцан адилгүй,
6. Дасгалын оройн шугамд загвар нуруугаар харж нисээгүй бол -”0” оноо



М-8. Давхар Иммельман, эхлээд 2/2 байрлалт торх, дараа нь бүтэн торхтой (Салхины уруу)

Оноо бууруулах:


1. Хагас цагирагууд зөв тойрог үүсгээгүй, тэдгээрийн радиус харилцан адилгүй,
2. Хагас цагаригт орох болон гарах цэгүүд бие биеийн чанх дээр байж чадаагүй,
3. Дасгалын хэвтээ шугамуудын урт нь хагас цагирагуудын диаметртэй тэнцүү бус,
4. Хагас цагаригийг хийж дуусмагц торхыг хийгээгүй,
5. Торхнуудын эргэлтийн хурд жигд бус,
6. Хагас цагариг болон торх хийх явцад нислэгийн чиглэл алдагдсан,
7. Дасгалд орох болон дасгалаас гарах өндөр адил бус, нислэг тэгш бус,
8. Торхнуудын эргэлт илүү эсвэл дутуу,
9. Торх бүхий нислэгийн шугамууд тэгш бус, хэвтээ бус



М-9. Зогсолттой эргэлт, дээш бүтэн торхтой (Захын)

Оноо бууруулах:

1. Өгсөх ба шумбах нислэгийн шугам эгц босоо бус,
2. Цагаригуудын сегментүүд зөв тойрог үүсгээгүй, тэдгээрийн радиус харилцан адилгүй,
3. Босоо шугамын нислэгийн чиглэл алдагдсан,
4. Зогсолттой эргэлтийн радиус далавчны $1/2$ -ээс их,
5. Зогсолттой эргэлтийн дараа савлах хөдөлгөөн үүссэн,
6. Торхыг өгсөх нислэгийн шугамын голд хийгээгүй.




М-10. Урвуу Куба найм, 2/4 байрлалт торхуудтай (Салхины өөд)

Оноо бууруулах:

1. Цагаригууд зөв тойрог үүсгээгүй, тэдгээрийн радиус харилцан адилгүй,
2. Цагариг болон торх хийх үед нислэгийн чиглэл алдагдсан,


3. Торхнуудын 45° -ын шугамуудын голд хийгээгүй,
4. Торхны эргэлт илүү, эсвэл дутуу,
5. Уруудах болон өгсөх нислэгийн шугамууд 45° биш.



М-11. “Аварга загасны шүд”, дээш хагас торх, 45° уруудах шугамд эсрэг эргэлттэй 2 хагас торхтой (Захын)

Оноо бууруулах:


1. Цагаригуудын сегментүүд зөв тойрог үүсгээгүй, тэдгээрийн радиус харилцан адилгүй,
2. Уруудах нислэгийн шугам 45° бус,
3. Өгсөх нислэгийн шугам эгц босоо бус,
4. Торхнуудын эргэлт илүү, эсвэл дутуу,
5. Торхнуудын тухайн шугамуудын эгц голд хийгээгүй,
6. Торхнуудын эргэх хурд жигд бус,
7. Дараагийн хагас торхыг эхний хагас торхны дараа шууд залгуулж хийгээгүй.



М-12. “Z” нислэг, дээш хагас торхтой (Салхины уруу)

Оноо бууруулах:


1. Өгсөх нислэгийн шугам 45° бус,
2. Цагаригуудын сегментүүд тойрог үүсгээгүй, тэдгээрийн радиус харилцан адилгүй,
3. Цагаригийн сегментүүд болон торх хийх үед нислэгийн чиглэл алдагдсан,
4. Торхыг тухайн шугамууд эгц голд хийгээгүй,
5. Торхны эргэлт илүү, эсвэл дутуу.



М-13. Дээрээс эхлэх, урвуу оролттой, өнцөгдсөн хагас дөрвөлжин цагариг (Захын)

Оноо бууруулах:


1. Цагаригуудын сегментүүд зөв тойрог үүсгээгүй, тэдгээрийн радиус харилцан адилгүй,
2. Хагас дөрвөлжингийн талууд тэнгэрийн хаяатай 45 градус үүсгээгүй,
3. Хагас дөрвөлжингийн талуудын урт тэнцүү бус,
4. Цагаригуудын сегментүүдийг болон 45 градус шугамыг хийх үед нислэгийн чиг алдагдсан.



M-14. “M” нислэг, 1/4 торхуудтай (Салхины өөд)

Оноо бууруулах:

1. Хагас цагаригууд зөв тойрог үүсгээгүй, тэдгээрийн радиус харилцан адилгүй,
2. Өгсөх болон шумбах нислэгийн шугам эгц босоо бус,
3. Зогсолттой эргэлтийн радиус далавчны далайцын 1/2 ээс их,
4. Зогсолттой эргэлтийн дараа савлах хөдөлгөөн үүссэн,
5. Торхуудыг өгсөх болон шумбах нислэгийн шугамуудын голд хийгээгүй,
6. Торхуудын эргэлт илүү эсвэл дутуу,
7. Төвийн хагас цагаригийн доод цэг болон оролт, гаралтын шугамууд адил өндөрт бус,
8. Төвийн хагас цагариг урвуу бус -”0” оноо



Санамж:

Торх болон зогсолттой эргэлтүүдийн чиглэл ямар ч байж болно.



М-15. “Гутал” /сонголттой - өгсөх шугамд хагас торх, эсвэл өгсөх, уруудах шугамд тус бүр 1/4 торхтой (Захын)

Санамж:

1. Хагас цагариг эсрэг, эсвэл эсрэг байж болно,
2. Дасгалд орох ба гарах өндөр өөр байж болно.

Оноо бууруулах:


1. Өгсөх ба уруудах нислэгийн шугам эгц босоо биш,
2. Торхыг босоо шугамын голд хийгээгүй,
3. Торхын эргэлт илүү эсвэл дутуу,
4. Цагаригуудын сегментүүд зөв тойрог үүсгээгүй, тэдгээрийн радиус харилцан адилгүй,
5. 1/4 торхтой гутал сонгосон тохиолдолд хагас цагариг нь нислэгийн шугамтай перпендикуляр биш.



М-16. Дөрвөн байрлалт торх (Салхины уруу)

Оноо бууруулах:


1. Байрлалт торхны байрлалууд 90° , 180° , 270° , 360° биш,
2. Төвийн 180° байрлалыг талбайн төв шугамд хийгээгүй,
3. Торхнуудын эргэлтийн хурд тогтмол бус,
4. $1/4$ торх бүрийн дараа завсарлага хийгээгүй,
5. Завсарлагуудын хугацаа харилцан адилгүй,
6. Торх хийх үед нислэгийн өндөр өөрчлөгдсөн,
7. Нислэгийн чиглэл алдагдсан.



М-17. Хагас дөрвөлжин цагариг, дээш 2/4 байрлалт торхтой (Захын)

Оноо бууруулах:


1. Цагаригуудын сегментүүдийн радиус харилцан адилгүй,
2. Цагаригуудын сегментүүдийг хийх үед загварын нислэгийн чиглэл алдагдсан,
3. Өгсөх нислэгийн шугам эгц босоо биш,
4. Торхыг өгсөх шугамын голд хийгээгүй,
5. Торхны эргэлт илүү эсвэл дутуу,
6. Торхны эргэлтийн хурд тогтмол бус



М-18. Гурван эргэлттэй штопор (Салхины өөд)

Оноо бууруулах:


1. Штопортой торхоор, эсвэл зогсолт хийхгүйгээр штопорт орсон – “0” оноо
2. Дасгалд орох үед загвар өндөр авч өгссөн, эсвэл өндөр алдаж шумбасан
3. Дасгалаас гарах үед загвар өндөр авч өгссөн, эсвэл өндөр алдаж шумбасан (төгсгөлийн $\frac{1}{4}$ цагаригийн дараа тэгш нислэгт шилжих үеийг “дасгалаас гарах үе” гэнэ)
4. Дасгалд орох ба дасгалаас гарах үед далавчны дагуу тэнхлэгийн түвшин тэгш бус
5. Загварын далавч хазайсны эсрэг зүгт штопорыг эргүүлсэн – “0” оноо
6. Штопороос гарах үед далавч нислэгийн шугамтай перпендикуляр биш
7. Спираль шумбаж, эсвэл загвар дагуу тэнхлэгээ тойрон хагасаас илүү эргэлт хийсэн бол – “0” оноо
8. Штопорын үед загварын сүүл конус зураагүй – “0” оноо
9. Загварын хошуу хэвтээ хавтгайг огтлохоос өмнө загварын далавч босоо хавтгайг огтолсон (штопортой торхоор орсон) - “0” оноо
10. Штопор эхлэхээс өмнө загварын их бие босоо байрлалд орсон - “0” оноо



Суултын өмнөх оноогүй шулуун нислэг (Салхины уруу)

Санамж

1. Салхины уруу суулт хийхгүйн тулд тамирчин суултын өөр чиглэлийг сонгож болох ба үүнд оноо хасахгүй
2. Загвар хөөрсний дараа салхины чиглэл өөрчлөгдсөн тохиолдолд л тамирчин суултын өөр чиглэлийг сонгох эрхтэй.
3. Суултын чиглэлээ өөрчилсөн бол суултад бэлдэх зорилгоор шүүгчдийн өмнүүр хоёроос дээшгүй удаа шулуун нислэг хийж болно.
4. Гэхдээ шулуун нислэгүүдийн хоорондох эргэлтүүдийг нислэгийн талбайн голд хийж болохгүй



М-19. Суулт (Салхины өөд)

Оноо бууруулах

1. Загвар нислэгийн аюулгүйн шугамыг давсан бол “0” оноо
2. Загвар өргөх хүчгүй болсны улмаас газар цохиж газардсан
3. Загвар газардсаны дараа “ямаа харайсан”
4. Нислэгийн чиглэл алдагдсан
5. Загвар нуруун дээрээ буусан бол “0” оноо
6. Загвар суултын талбайн гадна газардсан (гэхдээ гүйлтийн талбайн дотор)
7. Загварын дугуй суулт дуусахаас өмнө эвхэгдсэн бол “0” оноо
8. Загвар суултад орж явахдаа, эсвэл планердаж явахдаа “цогисон”, нислэгийн чиг алдагдсан
9. Загвар гүйлтийн талбайн гадна буусан бол “0” оноо
10. Загвар гүйлтийн шугамын дагуу чиглэлд газардаагүй.

Дараах тохиолдлуудад оноо хасахгүй:

1. Загвар буух үед агаарын хуйлралаас шалтгаалан далавч хазайх (хазайлтыг тэр дор нь зассан бол)
2. Хөндлөн салхинд загвар буух үед тамирчин загварын далавчийг хазайлгах
3. Загвар газардсаны дараа 10 хүртэл метр зайнд хяналттайгаар гүйгээд зогсох
4. Загвар суултын талбайд багтаж газардсан бол


Санамж

1. Загвар газраас 2 орчим метрийн өндөрт орж ирэхэд суултын дасгал эхэлсэнд тооцож оноо өгч эхэлнэ.
2. Загварын хамар бага зэрэг өргөгдсөн байдалтайгаар загвар хурдаа х асан тогтвортой планердаж суултын талбайд зөөлөн газардана.
3. Загвар газардсаны дараа 10 метр гүйснээр суултын дасгал дууссанд тооцож оноо өгөхийг зогсооно.

Суултын талбайн урт 30 метр, өргөн нь 30 метрээс ихгүй байна.



2020/21



	Мастер 2020 / 21	
	Дасгалууд	KF
1	Хөөрөлт	1
2	45° өгсөх нислэг, 4 байрлалт торхтой /Салхины өөд	4
3	Дээрээс эхлэх хагас дөрвөлжин цагариг, доош хагас торхтой /Захын	2
4	Удаан торх /Салхины уруу	2
5	Хагас куба найм, 45° уруудах шугамд бүтэн торхтой /Захын	3
6	Дээрээ суурьтай гурвалжин цагариг, эерэг штопор торхтой /Салхины өөд	5
7	Малгай, дээш 3/4 торх, доош 1/4 торхтой /Захын	4
8	Давхар иммельман, эхлээд 2/2 байрлалт торх, дараа нь бүтэн торхтой	5
9	Зогсолттой эргэлт, дээш бүтэн торхтой /Захын	3
10	Урвуу куба найм, 2/4 байрлалт торхуудтай /Салхины өөд	7
11	Аварга загасны шүд, дээш хагас торх, 45° уруудах шугамд эсрэг эргэлттэй	5
12	Z нислэг, дээш хагас торхтой /салхины уруу	3
13	Дээрээс эхлэх, уруу оролттой, өнцөгдсөн хагас дөрвөлжин цагариг /Захын	2
14	M нислэг, 1/4 торхуудтай /Салхины өөд	6
15	Гутал /сонголттой /Захын	3
16	Дөрвөн байрлалт торх /Салхины уруу	3
17	Хагас дөрвөлжин цагариг, дээш 2/4 байрлалт торхтой /Захын	3
18	Гурван эргэлттэй штопор /Салхины өөд	2
19	Суулт/Салхины өөд	1
	Нийт коэффициент	64